



ДОРНОГОВЬ АЙМАГ
АЙРАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/67

Цагаандөрвөлж

Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага
худалдаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.17 дахь заалт, 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/188 дугаар “Аргачлал шинэчлэн батлах тухай” тушаал, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн “Газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай” 08/02 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын газар зохион байгуулалтын 2026 оны төлөвлөгөөний дагуу хавсралтад дурьдагдсан газруудад эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн дуудлага худалдааг зохион байгуулсугай.

2.Газар эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг зохих журмын дагуу 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулахыг Газрын даамал (Т.Золбоо)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Туул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.ГАНБААТАР





05-06 дүгээр сарын 06. Айраг сумын Засаг даргын 2026 оны өдрийн 4/67 дугаар захирамжийн хавсралт

ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЖУРМААР ЭЗЭМШҮҮЛЭХ, АШИГЛУУЛАХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ДУУДЛАГА ХУДАЛДААГААР ЗАРЛАХ ҮНЭ

Д/д	Баг	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Газрын байршил	Газрын хэмжээ (м2)	Газрын зориулалт	Дуудлага худалдааны анхны үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)
1	4-р баг	5098102	Төмөр замын баруун талд	17454	Ачиж буулгах талбай	10,468,200	1,046,820
2	1-р баг	5098103	Төмөр замын баруун талд	16219	Ачиж буулгах талбай	9,726,600	972,660
3	2-р баг	5112490	33-р зөрлөгийн хойно	4712	Худалдаа нийтийн үйлчилгээтэй орон сууц	2,827,200	282,720
4	4-р баг	5112556	Замчин байр	632	Үйлчилгээтэй орон сууц	379,200	37,920
Нийт				39017		23,401,200	2,340,120

_____о-О-о_____